



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

**“Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн
холбоо, түүний гишүүн орнууд хооронд
байгуулсан худалдааны түр хэлэлцээрийн
маргаан шийдвэрлэх механизм”**

МОУА-ын нарийн бичгийн дарга Ш.Бүжинлхам



Хамрах хүрээ


Зөвхөн түр хэлэлцээрийн хүрээний асуудалд хамаарах бөгөөд талууд хэлэлцээрээр хүлээсэн үүргээ зөрчсөн, эсхүл хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж аль нэг тал үзвэл энэхүү маргаан шийдвэрлэх механизмыг хэрэглэнэ.



Зорилго

Маргааныг аль болох харилцан тохиролцож үр дүнтэй, үр ашигтай, ил тод шийдвэрлэх.

Үндсэн ойлголтууд



Зөвлөлдөх шат (Consultations)



Зөвлөлдөх хүсэлт гаргах

Гомдол гаргагч нь гомдол хүлээн авагч талын холбоо барих этгээд (Contact Point)-д хүсэлтийг бичгээр илгээнэ. Хүсэлтэд: маргааны шалтгаан, эрх зүйн үндэслэлийг тодорхой заана. Хамтарсан хороонд хүсэлтийн тухай мэдээллэнэ. (5.2)



Хариу өгөх хугацаа

Гомдол хүлээн авсан тал хүсэлтийг хүлээн авснаас хойш **10 хоногийн дотор** бичгээр хариу өгнө. (5.3)

(Талууд харилцан тохиролцож өөрчилж болно)



Зөвлөлдөөн эхлүүлэх

Гомдол хүлээн авсан тал хүсэлт хүлээн авснаас хойш **30 хоногийн дотор** зөвлөлдөөнийг эхлүүлнэ. (5.3)
Онцгой тохиолдолд (түргэн муудах бараа): 15 хоног. (5.4)

(Талууд харилцан тохиролцож өөрчилж болно)



Зөвлөлдөх

Хоёр тал бүрэн мэдээлэл солилцоно. Зөвлөлдөөний үед талуудад гаргаж өгсөн бүх мэдээлэл баримталсан байр суурь нууц байна. Зөвлөлдөх байршил: Гомдол хүлээн авсан талын нутаг дэвсгэр (эсвэл талуудын тохиролцооны дагуу боломжит технологийн хэрэгслээр). (5.7, 5.9)



Арбитрт хандах эрх үүснэ

Зөвлөлдөх хүсэлт гаргаснаас хойш **75 хоногийн дотор** талуудын хамтарсан зөвлөлдөөнөөр шийдэгдээгүй бол арбитрт хандаж болно. Онцгой тохиолдолд (Түргэн муудах бараа): 30 хоног. (7.16)

Арбитрт хандах үндэслэл:



01

Гомдол хүлээн авсан тал 10 хоног эсвэл 30 хоногийн хугацааны дотор хариу өгөх, зөвлөлдөх үүргээ биелүүлээгүй.




02

Зөвлөлдөх хүсэлтийг хүлээн авснаас хойш 75 хоногийн дотор (онцгой тохиолдолд 30 хоногт) шийдэлд хүрээгүй.




03

Зөвлөлдөөний үр дүнд тохирсон шийдвэрийг гомдол хүлээн авсан тал биелүүлээгүй.



Арбитрын бүрэлдэхүүн ба байгуулах журам



Арбитрын ажиллагаа эхэлсэн өдөр = Даргалагч арбитрч ажиллахыг зөвшөөрсөн өдөр



Арбитрчид тавигдах шаардлага



хууль эрх зүй, олон улсын худалдаа, энэхүү Хэлэлцээрт тусгагдсан бусад асуудал, олон улсын худалдааны хэлэлцээрийн дагуу үүссэн маргааныг шийдвэрлэхэд мэргэшсэн болон/эсхүл туршлагатай байх;



Гагцхүү бодит, шударга, найдвартай, зөв шүүн хэлэлцэх чадварын үндсэн дээр сонгогдох;



Аль нэг маргалдагч Талаас хараат бус, холбоо хамааралгүй, заавар зөвлөмж авдаггүй байх;



хувь хүнийхээ хувьд бие даан ажиллах, аливаа байгууллага, эсхүл засгийн газраас зааварчилгаа авдаггүй байх, эсхүл аль нэг маргалдагч Талын засгийн газарт харьяалагддаггүй байх;



Маргалдагч Талуудад хараат бус байдал, шударга байдлын талаар үндэслэл бүхий эргэлзээ төрүүлж болох аливаа асуудлыг, тухайлбал тухайн асуудлаар шууд болон шууд бус ашиг сонирхлын зөрчил байгаа эсэх талаар урьдчилан мэдэгдэх;



Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудтай дипломат харилцаатай улсын иргэн байх



Тухайн маргаанд өмнө нь оролцож байгаагүй байх



Арбитрын бүрэлдэхүүний даргалагч нь дараах шаардлагыг хангахгүй байж болно:

а. ЕАЭЗХ-ны гишүүн орон, эсхүл Монгол Улсын иргэн байх; эсвэл

б. ЕАЭЗХ-ны гишүүн орон, эсхүл Монгол Улсын иргэн байх

Ажлын даалгавар




Маргааны хүрээ



Хэрэглэх эрх зүй



Арбитрын бүрэлдэхүүний чиг үүрэг



Маргалдагч талууд арбитрын бүрэлдэхүүн байгуулах хүсэлт хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор дараах агуулга бүхий “ажлын даалгавар”-ыг тохиролцоно.

Арбитрын бүрэлдэхүүний чиг үүрэг ба арбитрын ажиллагаа

Чиг үүрэг

- Үүссэн асуудлыг бодитоор үнэлэх
- Тайлан болон шийдвэртээ үндэслэлийг тодорхой тусгах
- Талуудтай тогтмол зөвлөлдөж харилцан тохиролцсон шийдэлд хүрэх боломж олгох
- Хэрэгжүүлэх арга хэмжээний нийцлийг дүгнэх
- Хэлэлцээрийн заалтыг олон улсын нийтийн эрх зүйн зарчим (ultra vires...)д нийцүүлэн тайлбарлах



Шийдвэрийн хугацаа

- Ажлын хуваарь тогтоох→ 10 хоног
- Анхдагч шийдвэр гаргах→ 90 хоног (60)
- Шийдвэрт санал өгөх→ 15 хоног
- Нөгөө талын хариу санал→ 6 хоног
- Эцсийн шийдвэр гаргах→ 30 хоног (15)

Нийт=150 хоног (Онцгой тохиолдолд 80 хоног)

Ажиллагааг түдгэлзүүлэх болон дуусгавар болгох

Түдгэлзүүлэх: (Ажиллагааны аль ч үед)

- Талууд хамтран даргалагч арбитрчид хүсэлт гаргана.
- Түдгэлзүүлэх боломжит хугацаа 12 сар
- Ажиллагааг сэргээх хүсэлтийг аль ч тал гаргаж болно.
- Сэргээх хүсэлт ирүүлээгүй 12 сараас хэтэрвэл ажиллагаа дуусгавар болно.



Дуусгавар болгох: (Эцсийн шийдвэр гарахаас өмнө)

Талууд хамтран даргалагч арбитрчид хүсэлт гаргана.

Хамтарсан хороонд мэдэгдэнэ



Шийдвэр биелүүлэх үүрэг



01

Талууд арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг хойшлуулалгүй авна.



02

Эцсийн тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор:

- хэрэгжүүлэх арга хэмжээ,
- хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацааг мэдэгдэнэ.



03

Хамтарсан хороонд мэдэгдлийг тухай бүр мэдээллэнэ.



Шийдвэр биелүүлэх боломжит хугацаа:



01

Нэн даруй биелүүлэх боломжгүй бол талуудын хооронд "боломжит хугацаа"-г харилцан тохиролцоно.



02

Тохиролцоонд хүрэхгүй бол аль нэг тал Арбитрын бүрэлдэхүүнд хандаж хугацааг тогтоолгоно (30 хоногт шийдвэрлэнэ).



03

Биелүүлэх хугацаа дуусахаас 30-оос доошгүй хоногийн өмнө авсан арга хэмжээний талаар гомдол гаргагчид мэдэгдэнэ.



Шийдвэр биелэлтийн хяналт:



01

Шийдвэрийг биелүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нийцтэй эсэхэд маргаан гарвал гомдол гаргагч тал Арбитрын бүрэлдэхүүнд дахин хандаж болно.



02

Хүсэлтийг боломжит хугацаа дууссан эсвэл биелүүлснийг мэдэгдсэний дараа гаргаж болно.



03

Арбитрын бүрэлдэхүүн хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.



Шийдвэр биелүүлээгүйтэй холбоотой нөхөн олговор олгох болон түр арга хэмжээний зохицуулалт:



01

Шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол талууд 20 хоногийн дотор харилцан зөвшилцөж "нөхөн олговор"-т хүрэхийг эрмэлзэнэ.



02

Тохиролцоонд хүрэхгүй бол гомдол гаргагч тал хэлэлцээрт заасан хөнгөлөлийг түдгэлзүүлж болно (30 хоногийн өмнө урьдчилсан мэдэгдэнэ).



03

Хөнгөлөлт түдгэлзүүлэх нь биелүүлэх хүртэл зөвхөн түр арга хэмжээ байна.



Хэлэлцээрийн бусад заалтууд



Дүгнэлт

Арга барил

Хэлэлцээрийн маргаан шийдвэрлэх механизм-д зөвлөлдөх (consultation) арга барил давамгайлдаг.

Талуудын оролцоо

Талуудын идэвхтэй оролцоог шаарддаг.

Шийдвэрийн хэрэгжилт

Арбитрын шийдвэрийн биелэлтэд албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах боломж хязгаарлагдмал. Шийдвэрийн хэрэгжилтийн хяналт болон Түр арга хэмжээний зохицуулалт нь хэрэгжилтийг хангах баталгааны механизм болдог.

Арбитрч томилох процесс

Арбитрч томилох процесс Олон Улсын стандартад нийцсэн.

